



**НИЙСЛЭЛИЙН
СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

Денверийн гудамж-13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190
Утас: (976) 7010 7632
Цахим шуудан: SBD.KHAAA@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2024.01.22 № 15

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас зарласан СБДХААА/202412016 дугаартай “Дүүргийн Нэгдсэн эмнэлэгийн материаллаг бааз бэхжүүлэх” тендерийн баримт бичгийн:

1.ТШЗ-ын 18.6-д тусгасан Ижил төстэй гэрээний туршлага 2022, 2023 он тус бүрт батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [100] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, ижил төстэй барааны хувьд гэж заасаныг 2022, 2023 онуудын аль нэг жилд [70] хувиас багагүй нэг удаагийн гэрээтэй байх гэж залруулж байна.

2. ТШЗ-ын 18.3-д тусгасан тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг 2022, 2023 он гэж заасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.”, гэж заасныг үндэслэл болгосон ба энэ хугацаа нь харилцагч санхүүгийн байгууллагад цахимаар хүргүүлэх эцсийн хугацаа учир үүнийг санхүүгийн тайлан гаргах хугацаа гэж ойлгохгүйг анхаарна уу.